



ҮНДЭСНИЙ
ХУВЬЧЛАЛЫН
САН

Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Соёл амралтын хүрээлэн /1420/,
Энхтайвны өргөн чөлөө гудамж,
17 дугаартай Блюэ Скай барилгын 9 давхар
И-мэйл: info@ardmanagement.com Утас: 7700 3322

2026 он 4 сар 17 өдөр

Дугаар 26/03

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний жилийн тайлангийн
талаар дүгнэлт гаргах тухай*

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2.2, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, “Үндэсний хувьчлалын сан” Хамтын ХОС (цаашид “ХОС” гэх)-ийн дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.2.12-т заасныг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Ард Менежмент ХХК (“ХОМК”)-ийн Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний дагуу 2025 онд үзүүлсэн үйлчилгээ, тайланг хангалттай гэж дүгнэсүгэй.
2. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан тайланг Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж, зохих шийдвэр гаргуулахыг Нэгж эрх эзэмшигчдийн хурлын даргад үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Б.ЗОЛБОО



ҮНДЭСНИЙ
ХУВЬЧЛАЛЫН
САН

Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Соёл амралтын хүрээлэн /1420/,
Энхтайвны өргөн чөлөө гудамж,
17 дугаартай Блюэ Скай барилгын 9 давхар
И-мэйл: info@ardmanagement.com Утас: 7700 3322

2026 он 4 сар 17 өдөр

Дугаар 26/04

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

“Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС-ийн 2025 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаар дүгнэлт гаргах тухай

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2.1, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11, 96 дугаар зүйлийн 96.1, “Үндэсний хувьчлалын сан” Хамтын ХОС (цаашид “ХОС” гэх)-ийн дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.2.9-т заасныг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Нэксиа Глобал Монголиа Аудит ХХК-ийн гаргасан 2025 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар ХОС-ийн санхүүгийн тайланд хийсэн дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.
2. ХОС-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай гэж дүгнэсүгэй.
3. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж, зохих шийдвэр гаргуулахыг Нэгж эрх эзэмшигчдийн хурлын даргад үүрэг болгосугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Б.ЗОЛБОО



ҮНДЭСНИЙ
ХУВЬЧЛАЛЫН
САН

Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Соёл амралтын хүрээлэн /1420/
Энхтайвны өргөн чөлөө гудамж,
17 дугаартай Блюю Скай барилгын 9 давхар
И-мэйл: info@ardmanagement.com Утас: 7700 3322

2026 он 4 сар 17 өдөр

Дугаар 26/05

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Кастодиан банкны хөрөнгө хадгалах үйлчилгээний жилийн тайлангийн талаар дүгнэлт гаргах тухай

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2.2, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11, “Үндэсний хувьчлалын сан” Хамтын ХОС (цаашид “ХОС” гэх)-ийн дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.2.12-т заасныг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Голомт банк ХК-ийн Кастодиан Банкны хэлтсийн хөрөнгө хадгалах үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу үзүүлсэн үйлчилгээний 2025 оны жилийн тайланг хангалттай гэж дүгнэсүгэй.
2. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан хөрөнгө хадгалах үйлчилгээний жилийн тайланг Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж, зохих шийдвэр гаргуулахыг Нэгж эрх эзэмшигчдийн хурлын даргад үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Б.ЗОЛБОО



ҮНДЭСНИЙ
ХУВЬЧЛАЛЫН
САН

Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Соёл амралтын хүрээлэн /1420/,
Энхтайвны өргөн чөлөө гудамж,
17 дугаартай Блюэ Скай барилгын 9 давхар
И-мэйл: info@ardmanagement.com Утас: 7700 3322

2026 он 4 сар 17 өдөр

Дугаар 26/06

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

“Хөрөнгө хадгалах, кастодиан үйлчилгээний гэрээ”-г хугацаанаас өмнө цуцлах, Сангийн хөрөнгө хадгалах эрхийг Хаан банк ХК-д олгох тухай

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2.2, “Үндэсний хувьчлалын сан” Хамтын ХОС (цаашид “ХОС” гэх)-ийн дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.2.12, 12 дугаар зүйлийн 12.3.12, Голомт банк ХК-тай 2020 оны 6 сарын 09-ний өдөр байгуулсан “Хөрөнгө хадгалах, кастодиан үйлчилгээний гэрээ”-ний 12 дугаар зүйлийн 12.3.3-т заасныг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Голомт банк ХК-тай байгуулсан “Хөрөнгө хадгалах, кастодиан үйлчилгээний гэрээ”-г хугацаанаас өмнө цуцлах, Сангийн хөрөнгө хадгалах эрхийг Хаан банк ХК-д олгох саналыг тус тус Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлаар оруулж шийдвэрлүүлсүгэй.
2. “Хөрөнгө хадгалах, кастодиан үйлчилгээний гэрээ”-г хугацаанаас өмнө цуцлах тухай үндэслэл, шалтгааныг Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж, зохих шийдвэр гаргуулахыг Нэгж эрх эзэмшигчдийн хурлын даргад үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолд холбогдуулан Сангийн дүрэм, Хөрөнгө оруулалтын бодлого болон Нэгж эрхийн танилцуулга дахь Кастодиан банкны мэдээлэлд өөрчлөлт оруулснаар танилцуулж, шийдвэрлүүлсүгэй.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Б.ЗОЛБОО



2026 он 4 сар 17 өдөр

Дугаар 26/07

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Нэгж эрх эргүүлэн худалдан авах болон
буцаан зах зээлд арилжих журам батлах тухай*

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2.2, “Үндэсний хувьчлалын сан” Хамтын ХОС (цаашид “ХОС” гэх)-ийн дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.2.12, 12 дугаар зүйлийн 12.3.12-т заасныг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Сангийн нэгж эрхийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагчийн эзэмшиж буй хөрөнгийн үнэ цэнийг өсгөх зорилгоор өөрийн нэгж эрхийн зах зээлийн ханш тухайн үеийн цэвэр хөрөнгийн үнэлгээ (NAV)-ээс 15 ба түүнээс дээш хувиар бага үнэлэгдэж байгаа тохиолдолд Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан өөрийн нэгж эрхийг худалдан авахтай холбоотой ерөнхий нөхцөлийг энэхүү тогтоолын Нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Сангийн Нэгж эрх эргүүлэн худалдан авах болон буцаан зах зээлд арилжих журмыг энэхүү тогтоолын Хоёрдугаар хавсралтаар баталж, журмын дагуу холбогдох өөрчлөлтүүдийг Сангийн дүрэм, Хөрөнгө оруулалтын бодлого, Нэгж эрхийн танилцуулгад тус тус тусгаснаар Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж, шийдвэрлүүлсүгэй.
3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Сангийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 10 сарын 31-ний өдрийн 25/11 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Б.ЗОЛБОО

“Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС-ийн Төлөөлөн Удирдах
Зөвлөлийн 2026 оны 4 сарын 17-ны өдрийн 2/07 тоот
тогтоолын Нэгдүгээр хавсралт



№	ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН ХАМТЫН ХОС-ИЙН НЭГЖ ЭРХИЙГ ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАН АВАХ НӨХЦӨЛ	
1	Нэгж эрхийг эргүүлэн худалдан авах нөхцөл	Нэгж эрхийн зах зээлийн ханш тухайн үеийн цэвэр хөрөнгийн үнэлгээ (NAV)-ээс 15 ба түүнээс дээш хувиар бага үнэлэгдэж байгаа тохиолдолд зах зээлээс эргүүлэн авна.
2	Нийт гаргасан нэгж эрх	50,000,000 ширхэг
3	Эргүүлэн худалдан авах хувь	5 хувь хүртэл
4	Эргүүлэн худалдан авах нийт нэгж эрхийн тоо	2,500,000 ширхэг хүртэл
5	Эргүүлэн худалдан авах ажиллагаа хэрэгжих хугацаа	2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл

“Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС-ийн Төлөөлөн Удирдах
Зөвлөлийн 2026 оны 4 сарын 17-ны өдрийн 26/07 тоот
тогтоолын Хоёрдугаар хэвсрэлт



“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” ХАМТЫН ХОС-ИЙН НЭГЖ ЭРХ ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАН АВАХ БОЛОН БУЦААН ЗАХ ЗЭЭЛД АРИЛЖИХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. “Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС (цаашид “Сан” гэх)-ийн Нэгж эрх эргүүлэн худалдан авах болон буцаан зах зээлд арилжих журам (цаашид “Журам” гэх)-аар Сангийн нэгж эрхийг Монголын Хөрөнгийн Бирж (цаашид “МХБ” гэх)-ээр дамжуулан энэхүү Журмын 2.2 дахь хэсэгт заасан нөхцөлийн дагуу эргүүлэн худалдан авах ажиллагааг зохицуулна.
- 1.2. Энэхүү журам нь Монгол Улсын Иргэний хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Сангийн дүрэм, Үнэт цаасны бүртгэлийн журам, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын тухай журам болон холбогдох бусад хууль тогтоомжийн актаас бүрдэнэ.
- 1.3. Энэхүү журам нь холбогдох хууль, эрх зүйн хэм хэмжээний акттай зөрчилдсөн тохиолдолд холбогдох хууль, эрх зүйн хэм хэмжээний актыг баримтална.

ХОЁР. ЖУРМЫН ЗОРИЛГО, ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ

- 2.1. Энэхүү Журмын зорилго нь Сангийн нэгж эрхийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, үнэт цаасны зах зээлд тогтвортой оролцоо бий болгох зорилгоор нэгж эрхийг олон нийтээс эргүүлэн худалдан авах үйл ажиллагааг зохицуулахад оршино.
- 2.2. Энэхүү Журам нь Сангийн баталсан хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд өөрийн нэгж эрхийн зах зээлийн ханш тухайн үеийн цэвэр хөрөнгийн үнэлгээ (NAV)-ээс 15 ба түүнээс дээш хувиар бага үнэлэгдэж байгаа тохиолдолд МХБ-ээр дамжуулан өөрийн нэгж эрхийг буцаан худалдан авах үйл ажиллагаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

ГУРАВ. НЭГЖ ЭРХИЙГ ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАН АВАХ НӨХЦӨЛ

- 3.1. Эргүүлэн худалдаж авах нэгж эрхийн нийт хэмжээ нь Сангийн гаргасан нийт нэгж эрхийн 5 хувиас хэтрэхгүй байна.
- 3.2. Нэгж эрхийг МХБ-ээр дамжуулан зах зээлээс эргүүлэн худалдан авна.
- 3.3. Эргүүлэн худалдаж авах үйл ажиллагааг дараах хязгаарын хүрээнд явуулна:
 - 3.3.1. Нэгж эрхийн зах зээлийн ханш тухайн үеийн цэвэр хөрөнгийн үнэлгээ (NAV)-ээс 15 ба түүнээс дээш хувиар бага үнэлэгдэж байгаа тохиолдолд Монголын Хөрөнгийн биржээр дамжуулан өөрийн нэгж эрхийг буцаан худалдан авах.

ДӨРӨВ. НЭГЖ ЭРХИЙГ БУЦААН ЗАХ ЗЭЭЛД АРИЛЖИХ НӨХЦӨЛ

- 4.1. Энэхүү Журмын дагуу Сангийн эргүүлэн худалдан авсан нэгж эрхийг буцаан зах зээлд арилжих ажиллагаа нь Сангийн нэгж эрхийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, нэгж эрх эзэмшигчдийн эрх, ашгийг хамгаалах зорилготой байна.
- 4.2. Сангийн нэгж эрхийн цэвэр хөрөнгийн үнэлгээ (NAV) нь зах зээлийн ханшаас 15 ба түүнээс дээш хувиар өссөн тохиолдолд Сан нь эргүүлэн худалдан авсан нэгж эрхээ буцаан зах зээлд арилжиж болно.

- 4.3. Энэхүү Журмын 4.2-т заасны дагуу буцаан арилжих нэгж эрхийн тоо, арилжих хугацаа, холбогдох бусад журмыг Сангийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосноор Сангийн менежер нь МХБ-ийн арилжааны журамд нийцүүлэн тухайн нэгж эрхийг олон нийтэд санал болгон арилжаалах ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 4.4. Буцаан гаргах нэгж эрхийн санал болгох үнэ нь тухайн үеийн цэвэр хөрөнгийн үнэлгээ (NAV) болон зах зээлийн арилжааны ханшийн зөрүүг харгалзан, Сангийн ТУЗ-өөс тогтоосон доод/суурь үнэтэй байх бөгөөд эцсийн арилжааны үнэ нь МХБ-ийн арилжааны журмын дагуу тогтоно.
- 4.5. Сангийн үйл ажиллагаа явуулах хугацаанд энэхүү Журмын 4.2-т заасан нөхцөл биелээгүй тохиолдолд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд заасан нөхцөл, журмын дагуу сангийн хөрөнгийг нэгж эрх эзэмшигч гишүүдэд хуваарилна.
- 4.6. Сан нь үнэ тогтох болон нэгж эрхийг буцаан арилжих ажиллагааг нэгж эрх эзэмшигч, хөрөнгө оруулагчдад шударга, ил тод байдлаар өөрийн болон МХБ-ийн сайтаар мэдээлж ажиллана.
- 4.7. Нэгж эрхийг буцаан зах зээлд арилжих хугацааг нэгж эрхийн цэвэр хөрөнгийн үнэлгээний өсөлтөөс хамааран Сангийн ТУЗ-ийн шийдвэрээр тогтооно.
- 4.8. Энэхүү Журмын 4.6-д заасны дагуу буцаан зах зээлд арилжих хугацааны талаар шийдвэр гарснаар ажлын нэг өдрийн дотор Сан нь Санхүүгийн зохицуулах хороо болон МХБ-д тус тус бичгээр мэдээлнэ.

ТАВ. НЭГЖ ЭРХИЙГ ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАЖ АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧИЙН БҮРЭН ЭРХ

- 5.1. Сангийн ТУЗ нь дараах бүрэн эрхтэй.
 - 5.1.1. Энэхүү журамд нэмэлт, өөрчлөлт оруулах;
 - 5.1.2. Энэхүү журамд заасны дагуу эргүүлэн худалдаж авсан сангийн нэгж эрхийг буцаан гүйлгээнд оруулах;
 - 5.1.3. Энэхүү журамд заасан нэгж эрхийг буцаан арилжих хугацаа, журмыг шинэчлэн тогтоох;
 - 5.1.4. Нэгж эрхийг эргүүлэн худалдаж авах асуудлаар хяналт тавих, зөвлөмж гаргах, үүрэг даалгавар өгөх, зогсоох.
- 5.2. Сангийн менежер нь нэгж эрхийг эргүүлэн худалдаж авахтай холбоотой дараах бүрэн эрхтэй:
 - 5.2.1. Нэгж эрхийг эргүүлэн худалдаж авах ажиллагааг ТУЗ-өөс олгосон бүрэн эрх, энэхүү журамд заасан хүрээнд удирдан зохион байгуулах;
 - 5.2.2. Энэхүү журмын хэрэгжилт, эргүүлэн худалдаж авсан нэгж эрхийн талаарх мэдээллийг ТУЗ-д тайлагнах;
 - 5.2.3. Нэгж эрхийг эргүүлэн худалдаж авахтай холбоотой аливаа гэрээ, хэлцэл байгуулах, захиалгын хуудаст компанийн төлөөлж гарын үсэг зурах;
 - 5.2.4. Сан нь нэгж эрхийг эргүүлэн худалдаж авах ажиллагаанд аливаа ашиг сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлэх.

ЗУРГАА. ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ ХУГАЦАА

- 6.1. Энэхүү журмын дагуу холбогдох өөрчлөлтүүд Сангийн дүрэм, Хөрөнгө оруулалтын бодлого, Нэгж эрхийн танилцуулгад тус тус орж, Санхүүгийн зохицуулах хорооноос холбогдох зөвшөөрөл ирснээр хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 6.2. Энэхүү Журмын үйлчлэх хугацааг сунгах, хүчингүйд тооцохтой холбоотой бүрэн эрхийг Сангийн ТУЗ хэрэгжүүлнэ.

ДОЛОО. БУСАД

- 7.1. Энэхүү журам хүчин төгөлдөр үйлчлэх нөхцөл бүрдсэнээр Сан нь дараах мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороо, МХБ болон өөрийн цахим хуудсаар нийтэд ил тод мэдээлнэ. Үүнд:
- 7.1.1. Нэгж эрхийг эргүүлэн худалдан авах тухай шийдвэр;
 - 7.1.2. Нэгж эрхийг эргүүлэн худалдан авах хугацаа;
 - 7.1.3. Нэгж эрхийг буцаан зах зээлд арилжих хугацаа;
 - 7.1.4. Нэгж эрхийн зах зээлийн ханшийн харьцуулалт;
 - 7.1.5. Хууль, тогтоомж, Санхүүгийн зохицуулах хороо, МХБ-ээс тогтоосон бусад.
- 7.2. Энэхүү журмын хэрэгжилтийг ТУЗ болон сангийн менежер хангаж ажиллана.
- 7.3. Энэхүү журмаар зохицуулаагүй бусад харилцааг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Иргэний хууль, Сангийн дүрэм, Үнэт цаасны бүртгэлийн журам, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын тухай журамд тус тус заасны дагуу зохицуулна.
